



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар Д/116

Хэрлэн сум

Энгийн болон онцгой хамгаалалтын
бүс тогтоох ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, төвлөрсөн болон төвлөрсөн бус усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоох, санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар байгуулсугай.


2. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг тогтоох ажлын хэсгийн ажиллах түр журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсгээс боловсруулсан саналаа 2023 оны 6 дугаар сарын 30-ны дотор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг Ажлын хэсгийн дарга (Б.Дархантөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 03-ны өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Дарга	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Нарийн бичиг	Б.Нандинцэцэг	Хэрлэн голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (зөвшилцсөнөөр)
Гишүүд	Б.Баяртогтох	Онон, Улз голын сав газрын захиргааны дарга (зөвшилцсөнөөр)
	Б.Отгонсүрэн	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны дарга (зөвшилцсөнөөр)
	Ж.Энх-Амгалан	Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга
	Б.Мөнхчимэг	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Газрын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Б.Хашмаргад	Хан Хэнтийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга (зөвшилцсөнөөр)
	О.Цэндгомбо	Онон балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (зөвшилцсөнөөр)
Р.Жавхлан	Гутайн даваа шургадагийн голын эхийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (зөвшилцсөнөөр)	
		Сумдын Засаг дарга нар



Ажлын хэсгийн ажиллах түр журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү түр журмын зорилго нь Монгол Улсын Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 13 дугаар зүйлийн 13.1.6, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан А-230/127 тушаалын хавсралт журмын дагуу Хэнтий аймгийн 18 сумын нутаг дэвсгэрт усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг тогтоох, ажил үүргийн хуваарь, ажил зураглал, төсөл, санал боловсруулахтай холбогдсон харилцааг хуулийн хүрээнд зохицуулахад оршино.

1.2 Аймгийн Засаг даргын удирдамжийг үндэслэн сумдад ажиллах дэд ажлын хэсгийг бүрэлдэхүүн, сумдад ажиллах хуваарь, хийх ажлыг тусгаж өгнө.

Хоёр. Ажлын хэсгийн зорилго

2.1 Хэнтий аймгийн нийт сумын нутаг дэвсгэрт аймаг ИТХ-ын тогтоолоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын эрүүл ахуйн бүсийг тогтоох ажил үүргийн хуваарь ажлын зураглал, төсөл санал боловсруулахтай холбогдсон харилцааг хуулийн хүрээнд зохицуулахад оршино.

Гурав. Ажлын хэсгийн үйл ажиллагааны чиглэл

3.1 Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг тогтоох ажлын зураглал, санал, тогтоолын төсөл боловсруулах.

3.2 Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийн цэсийг баталгаажуулах санал болно.

3.3 Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг тогтоох явцад аль болох газрын эзэмшил, өмчлөл, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талаарх маргаан бага гарах хувилбарыг сонгохыг эрмэлзэнэ. Маргаан гарах тохиолдолд зөвхөн хуулийн хүрээнд шийдвэрлэх зарчмыг баримтална.

3.4 Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг тогтооходоо урьдчилан байрзүйн дэвсгэр зураг, хиймэл дагуулын зураг, кадастрын зураглал дээр ажилласны дараа тухайн газарт нь бодит байдалтай тулгалт, хэмжилт хийх, нягтлах, алдаагүй байгааг батлах зарчмаар ажиллана.

3.5 Үйл ажиллагаанд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг бүрэн хамруулах, тэдний санал бодлыг сонсох, гаргасан зөв оновчтой шийдлийг нь шийдвэрт тусгах зэргээр ажиллана.

3.6 Гишүүд ажлын зорилго, зарчим, туршлагад тулгуурлан усны сан бүхий газрын үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг үнэн зөв тогтоохыг гишүүд хариуцна.

Дөрөв. Ажлын хэсгийн үйл ажиллагаа, гаргах шийдвэр, баталгаажилт, хүрэх үр дүн

4.1 Сумдад ажилласан 2 ажлын хэсгийн хамгаалалтын бүсийн зураглал, тайлан, сумын ИТХ-ын шийдвэртэй танилцаж аймгийн Засаг даргад танилцуулах

4.2 Захиргааны ерөнхий хуулийн дагуу Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн

хугацаанд байрлуулж санал авна Сонсох ажиллагаа, нөлөөллийн шинжилгээ хийх ажлын зохион байгуулах

4.3 Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т хуульчилсны дагуу Барилга, хот байгуулалтын яам болон Байгаль, орчин аялал жуулчлалын яамнуудаас аль алинаас нь дүгнэлт гаргуулах үндэслэлтэй байгааг дурдаж, албан бичиг хүргүүлж дүгнэлт гаргаж авах

4.4 Ажлын хэсэг 2 яамны дүгнэлтийг үндэслэн аймгийн ИТХ-д хамгаалалтын бүс тогтоох төслийг танилцуулж тогоол гаргаж баталгаажуулах

4.5 Аймгийн ИТХ-ын тогтоолыг ажлын 5 хонгийн дотор Хууль зүйн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актаар бүртгүүлэх.

4.6 Аймгийн ИТХ-ын Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, Усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн болон хязгаарлалтын бүсийг тогтоолыг сумдад болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага олон нийтэд сурталчлан таниулах, хамгаалалтын бүсийн дэглэм горимыг мөрдөх хэрэгжилтийг хангах нь ажлын хэсгийн ажлын үр дүн болно.